



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 165

Мандалговь

Автомашиныг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77,4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журамын 3 дугаар зүйлийн 3.1“в” 3.2.6-гийн “а” заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Тээвэр авто замын газарт ашиглагдаж байгаа 56-66 ДУА улсын дугаартай УАЗ-31514 машиныг байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт зэрэг баримт бичигээр үндэслэн ажлын шаардлага хангахгүй болсон тул худалдахыг зөвшөөрсүгэй.

2. 1994 онд ашиглалтад орсон 56-66 ДУА улсын дугаартай УАЗ 469 маркын автомашиныг 2,0 сая төгрөгөөр худалдах доод үнийг тогтоон дуудлагаар худалдсугай.

3. Автомашиныг хүлээн авч дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Орон нутгийн өмчийн албанд даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНГӨНЦООЖ

53
0100000778

My doc.alban bichig.togtool